

Санжпэрлээгийн Энхболд¹, Эрдэнэ-Очирын Амарболд¹

¹Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар – 13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

Ар Гүнтийн хүннү булшны малтлага судалгааны зарим үр дүнгээс

Хураангуй. Ар Гүнтийн хүннүгийн булш оршуулгын дурсгал нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг, Жаргалантын давааны өвөрт орших бөгөөд нийслэл орчмын хамгийн том хүннүгийн булшны цогцолборын нэг юм. Монгол, Унгарын хамтарсан “Азийн хүннүчүүд ба Европын хүннүчүүдийн түүх, соёлын харилцаа, хамаарлын судалгаа” төслийн хүрээнд 2022 онд уг дурсгалт газарт 7 булшинд археологийн малтлага хийв. Малтлагын явцад нийт 1250 гаруй ширхэг археологийн болон зооархеологийн хэрэглэгдэхүүн илэрч, хүн, мал, нохой, шувуу, бугын яс зэрэг олон төрлийн олдвор цуглуулсан нь лабораторийн түвшний нарийвчилсан судалгаа хийх боломжийг бүрдүүлээ. Олдвор хэрэглэгдэхүүний хувьд төмөр тогоо, дашмагийн ясан бөглөөтэй амсар зэрэг ховор эдлэл илэрсэн нь хүннүгийн булшнаас анх удаа бүртгэгдэж буй шинэлэг олдвор бөгөөд энэ нь тус судалгааны онцлог, ач холбогдлыг улам тодотгож байна. Палеоантропологи шинжилгээгээр булшнууд дахь хүний ясыг судалж, нас, хүйс, биологийн онцлогийг тогтоосон бөгөөд ArG-06 дугаартай булшнаас авсан дээжид хийсэн археогенетикийн судалгаа уг булшны эзэн нь Монголын өндөрлөгөөс Унгарын тал хээрт нүүдэллэн очсон элит бүлэгтэй холбоотой болох, радиокарбоны шинжилгээгээр НТӨ II – НТ I зууны үед хамаарахыг тогтоосон. Ар гүнтийн хүннүгийн оршуулгын дурсгал нь Хүннүгийн нийгмийн бүтэц, оршуулгын зан үйл, тахил, тайлга болон дорно, өрнийн соёлын харилцааг судлахад чухал эх сурвалж болж байна.

Түлхүүр үг: Ар гүнт, хүннүгийн булш, археологийн малтлага, палеоантропологи, радиокарбон шинжилгээ, зооархеологи, оршуулгын зан үйл

Enkhbold Sanjperlee¹, Amarbold Erdene-Ochir¹

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace Avenue, Ulaanbaatar 13330, Mongolia

Some results of the excavation of the Xiongnu burial at Ar Gunt

Abstract. The Xiongnu cemetery site of Ar Gunt is located in the territory of the 21st khoroo at Songinokhairkhan District, Ulaanbaatar, in the foothills of Jargalant Pass, and is one of the largest Hunnu cemetery in the vicinity of the capital of Mongolia. In 2022, as part of the Mongolian-Hungarian joint project “Study of Historical and Cultural Relations between Asian and European Huns,” archaeological excavations were conducted on seven graves at this site. During the excavations, over 1,250 archaeological and zooarchaeological artifacts and materials were uncovered, including a wide range of human, animal (horse, dog, bird, deer), and other biological remains, creating opportunities for detailed laboratory analyses. In terms of material culture, rare artifacts such as the iron cauldron and the bone-stoppered Dashmag vessel rim were discovered. These items are newly documented in Xiongnu burials for the first time, highlighting the uniqueness and significance of this research. Paleoanthropological studies examined the human bones from the burials to determine age, sex, and biological characteristics. Ancient DNA analysis conducted on samples from burial ArG-06 revealed that the individual was likely associated with an elite group that migrated from the Mongolian Plateau to the Hungarian plains. Radiocarbon dating indicates that the burial dates to the 2nd BC–1st century AD. The Ar Gunt Hunnu cemetery site is an important source for studying the social structure, funerary customs, sacrificial rituals, and cultural interactions between the East and West during the Xiongnu period.

Keywords: Ar Gunt, Xiongnu burial, Archaeological excavation, Paleoanthropology, Radiocarbon dating, Zooarchaeology, Funerary practices

Удиртгал

Сүүлийн үеийн судалгаагаар Монгол болон хөрш ОХУ, БНХАУ-ын нутагт нийт 23 мянга орчим хүннүгийн булш, оршуулгын дурсгал бүртгэгдээд байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх буюу 21 мянга гаруй нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төвлөрсөн байна. Үлдсэн нь ОХУ-ын Буриад, БНХАУ-ын Өвөр Монгол, Ганьсу, Хөхнуур, Шинжаан зэрэг бүс нутгуудад тархжээ (Эрэгзэн нар, 2022).

Энэ нь Хүннүгийн археологийн судалгааг зөвхөн үндэсний төдийгүй Евразийн түүх, соёлын судалгаанд онцгой байр суурь эзлэхэд хүргэж байна.

Энэхүү ач холбогдлыг харгалзан Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн болон Унгар улсын Унгар судлалын хүрээлэн 2022 онд хамтран “Азийн хүннүчүүд ба Европын хүннүчүүдийн Түүх соёлын харилцаа, хамаарлын судалгаа” төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн гол зорилго нь Ар гүнтийн хүннүгийн булш, оршуулгын дурсгалын бүтэц зохион байгуулалт, хүн амын угсаа, гарлыг макро төвшинд судлах, түүнчлэн Улаанбаатар хоттой хамгийн ойр байрлах хүннүгийн цагариг хэлбэрийн булш бүхий оршуулгын газар болохын хувьд нийслэлийн түүхэн аялал жуулчлалын маршрутад оруулж дотоод, гадаадын жуулчдын зорин очих томоохон дурсгал болгох боломжтой юм.

Судалгааны хүрээнд 2022 онд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг Ар гүнтийн Хүннүгийн булш, оршуулгын дурсгалт газар археологийн судалгаа хийсэн бөгөөд 7 булш малтан судалжээ. Энэхүү дурсгал нь нийслэл орчмын хамгийн том хэмжээтэй Хүннүгийн оршуулгын газар бөгөөд бүтэц зохион байгуулалт, хүн, малын яс, тахил тайлга, олдворын хувьд ихээхэн онцлогтой юм.

Уг өгүүлэлд Ар гүнтийн дурсгалт газарт хийсэн археологийн малтлага судалгаа, палеоантропологи болон зооархеологийн судалгааны үр дүнг танилцуулж, оршуулгын зан үйл, олдвор хэрэглэгдэхүүн зэргийг сэргээн тайлбарлахыг зорив.

Судалгааны арга зүй

Ар гүнтийн хүннүгийн дурсгалын судалгааг Монгол, Унгарын хамтарсан төслийн хүрээнд орчин үеийн археологи, байгалийн шинжлэх ухааны шинжилгээний аргуудыг хослуулан хэрэгжүүллээ. Судалгааны эхний шатанд дурсгалт газрын морфологи, газар зүйн орчны онцлог, дурсгалын тархцыг тодорхойлох зорилгоор байрлал зүйн хэмжилт болон дэвсгэр зураглал хийж жипиз (GPS) болон тотал стэйшн (Total station) хэмжилтийн багажаар булшнуудын тархалт, хэмжээс чиглэлийг нарийвчлан бүртгэлээ. Ийнхүү хийсэн хайгуулын

үр дүнд өмнөх бүртгэлийн мэдээллийг шинэчлэн нийт 41 булш бүхий оршуулгын цогцолбор болохыг тогтоов.

Судалгаа хийх булшийг сонгохдоо оршуулгын дурсгалын төв хэсэгт 4 булш, зүүн 1 булш, баруун 1 булш, хамгийн хойд талд байрлах 1 булш гэх мэт нийт 7 булшийг сонгон малтан судалсан. Ингэж сонгосон нь зэрэг дэвийн ялгаа, он цагийн зөрүү, нас хүйс зэрэг олон чухал мэдээллийг авч харьцуулан судлах боломжийг олгох юм.

Малтлага судалгааг хөрсний ялгарал, чигжээс чулууны бүтэц, дараас чулууны тархалтыг анхааран үечлэн малтах зарчмаар явуулсан бөгөөд малтлагын явцад илэрсэн давхарга бүрд зохих гэрэл зураг, гар зураг болон хэмжилт хийж баримтжуулав. Оршуулгын нүх, тахилын хэсэг, хойлгын хөмгийн бүтэц, модон бунхан, авсны үлдэгдэл, тонуулын ул мөрүүдийг хөрсний зүсэлтийн зураг, видео бичлэг, 3D баримтжуулалтын аргаар бүрэн тэмдэглэн авсан.

Малтлагаар илэрсэн хүн болон мал, амьтны яс, төмөрлөг, мод, хүрэл, шавар ваар зэрэг олдворыг ангилан бүртгэж, лабораторийн түвшний боловсруулалт хийхээр материалын төрөл тус бүрээр ялгав. Хүний ясны хэрэглэгдэхүүнд хийсэн палеоантропологийн шинжилгээнд ясны хэмжил зүй, морфологийн үнэлгээ, гэмтэл, эмгэгийн ажиглалт зэрэг үндсэн аргачлалыг хэрэглэн нас, хүйс, биологийн онцлог, өвчний шинж, амьдралын хэв маягийн талаарх мэдээллийг тодорхойлов. Зарим булшны хүний ясан дээр илэрсэн гэмтлийн ул мөрийг микроморфологийн шинжилгээгээр баталгаажуулсан.

Зооархеологийн шинжилгээг малын төрөл зүйл, насны зэрэглэл, ясны бүтцийн хэлбэр, хэрэглээний ул мөр, тахилын болон хөмөг доторх байршилд тулгуурлан хүннүгийн булшны зан үйл болон малын хэрэглээний онцлогийг тогтоох үндэслэлийг бүрдүүлэв. Шатаалтын болон цохилтын ул мөр бүхий ясанд хийсэн микроскопын шинжилгээ нь тахилын зан үйлийн шинж чанарыг тодотгосон.

Дурсгалт газрын байршил, газар зүйн орчин.

Монгол Улсын Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг, Ар гүнт хэмээх газар хүрэл зэвсгийн үеэс Монголын үед холбогдох 86 тооны дурсгал нийт 7 газар бүлэглэн оршино (Эрэгзэн нар., 2022). Эдгээрээс хүннүгийн хамгийн олон булш бүхий газар бол Ар гүнтийн хүннүгийн булш оршуулгын дурсгал буюу Жаргалантын давааны өврийн хүннү булш юм. Энэхүү дурсгалт газар Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг, Жаргалант уулын урд бие, Жаргалантын давааны баруун талд, хоёр талаараа жалга бүхий амны дунд, наранд ээвэр бага зэрэг налуу энгэрт оршино. Уг дурсгалт газрын хөрс ерөнхийдөө

тачир ургамлын бүрхүүлтэй, шимт хөрсний зузаан дунджаар 10 см, түүний доор цайвар шаргал өнгийн шаварлаг хөрстэй байх ажээ (Зураг 2).

Дурсгалт газрын судлагдсан байдал.

Дурсгалт газрыг анх 2016 онд МУ-ын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн (хуучин нэрээр) эрдэм шинжилгээний ажилтан Н.Эрдэнэ-Очир, Б.Батдалай нар Улаанбаатар хотын СХД-ийн Соёлын Өвийн байцаагч нарын хамт Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалын бүртгэл, баримтжуулалтын ажлын хүрээнд нээн илрүүлсэн байдаг. Үүний дараагаар Монгол Улсын ШУТИС-ийн БУХС-ийн профессорын багийн судлаачид бүртгэн, баримтжуулж “Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх археологийн дурсгалууд” (Ванчигдаш, Эрдэнэболд нар., 2021: 321) бүтээлдээ хэвлүүлжээ.

2022 онд ШУА-ийн Археологийн хүрээлэн, Унгар улсын Унгар судлалын хүрээлэнгийн хамтарсан “Азийн хүннүүд ба Европын хүннүүдийн түүх, соёлын харилцаа хамаарлын судалгаа” төслийн археологийн хээрийн судалгааны анги дурсгалт газар хайгуул судалгаа хийж 41 тооны цагариг хэлбэрийн чулуун дарааст булш байгааг тогтоон дэвсгэр зураг үйлдсэний зэрэгцээ 7 булшийг малтан судалсан.

Булшны байрлал, зохион байгуулалт. Ар гүнтийн хүннүгийн булшнуудын газрын гадарга дээр ил гарсан дараас чулууны хэлбэр бүгд цагариг, дараас чулууны төв хэсэг чулуугүй, бага зэрэг ухагдсан мэт хонхойсон. Өнгөн хөрсөн дээр ил байрлах дараас чулууны голч жижиг нь 4.5 м, том нь 7 м голчтой (дараас чулууны хэмжээг хүснэгт 1-ээс харна уу).

Малтан судалсан 7 булшны 1, 2 дугаартай булш дурсгалт газрын төв хэсэгт хойноос урагш цуварсан

байрлалтай байсан бол 3, 4-р булш зэрэгцээ, 5-р булш дурсгалт газрын хамгийн хойд захад, 6-р булш хамгийн зүүн захад, 35-р булш хамгийн баруун урд захад байрлаж байсан.

Булшны нүх. Малтан судалсан булшнуудын оршуулгын нүх харилцан адилгүй гүнээс мэдэгдэж эхэлсэн ба 1-р булш 90 см, 2-р булш 70 см, 3-р булш 50 см, 4-р булш 60 см, 5-р булш 70 см, 6-р булш 60 см, 35-р булш 55 см-ээс тус тус илэрсэн (Зураг 3-9).

Нийт булшны бүтэц нь дараас чулуу, чигжээс чулуу, оршуулгын хэсэг гэсэн 3 үеэс бүтэж байв. Дараас чулууны доороос булшны нүх илэрч, түүний дундаас чигжээс чулуунууд гарч байсан. Булшны нүхний төв хэсгийн чигжээс чулуунууд эвдэгдэж харин хөл болон толгой тал руугаа бөөгнөрсөн байдалтай үргэлжилж оршуулгын хэсэг хүрсэн. Өнгөн хөрснөөс авс хүртэлх чигжээс чулуунуудын дундаас хүн, малын яс, авсны модны хэсгүүд цөөнгүй тоогоор гарч байв. Илэрч олдсон олдворууд булшны нүхний төв хэсгээс буюу хар хүрэн өнгийн хөрсөн дундаас илэрч байсан нь тонуулчдын ул мөр гэдгийг тодорхой харуулж байв.

1, 2-р булшны оршуулгын нүхний ханыг тэгшлэн засаж 2 см зузаантай улаан зосоор өнгөлсөн байсан нь малтлагын явцад илэрсэн (Зураг 10).

Малтан судалсан 7 дурсгалын 2, 3, 6-р булш хойлгын хөмөгтэй байсан ба хамгийн том нь 6-р булшных байв (Зураг 17). Уг булшны хөмгөөс нийт 20 гаруй бод, 50 гаруй бог малын яс илэрсэн.

Оршуулгын хэсгийн бүтэц. Малтан судалсан 7 булшны ArG-1, 2 дугаарт булш дүнзэн бунхантай, түүний дээр хөндлөн тавьсан зах банзан тагтай (Зураг 11,12). Уг бунхант булшнууд оршуулга, тахилын, хойлгын гэсэн 3 хэсгээс бүрдэх бол ArG-3, 4, 5, 6 дугаарт булшны авс нь оршуулга, тахилын

Хүснэгт 1. Ар гүнтийн Хүннү булшны бүтэц ба хэмжээ

Булшны дугаар	Дараасны голч (метр)	Чиглэл (Азимут)	Авс хүртэлх гүн (метр)	Оршуулгын нүхний хэмжээ (метр)	Шал хүртэлх гүн	Хойлгын хөмгийн хэмжээ (метр)
ArG-1	7	80	2.4	урт 3.5, толгой талын өргөн: 1.8, хөл талын өргөн: 1.2	3.1	-
ArG-2	7	70	3.1	урт 3.5, өргөн 1.5	3.6	амсрын өргөн 0.8, гүн 0.7
ArG-3	4.5	12	2.1	урт 2.9, өргөн 1.7	2.6	амсрын өргөн 0.8, өндөр 0.7 м, гүн 0.2
ArG-4	6.5	10	2.7	урт 3.2, өргөн 2.3	3.1	-
ArG-5	5.5	350	2.3	урт 2.5, толгой талын өргөн 1.5, хөл талдаа 1.2	2.8	-
ArG-6	6	10	2.3	урт 2.9, Толгой талдаа 1.7, хөл талдаа 1	3.8	амсрын өндөр 1.2, хөмгийн дотор өндөр 1.8, гүн 1.2
ArG-35	6	5	2.9	урт 2.5, толгой талын өргөн 1 м, хөл талдаа 0.87 м,	3.3	-

гэсэн 2 тасалгаатай (Зураг 13, 14, 15). Харин ArG-35 дугаарт булшны авс ямар нэгэн тасалгаагүй, дээрээ уртааш нь тавьсан банзан тагтай байв (Зураг 16).

Олдвор хэрэглэгдэхүүн. Малтан судалсан бүх булш тоногдож гадаад, дотоод зохион байгуулалт алдагдсан хэдий ч цөөнгүй тооны олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдсоныг доор сийрүүлбэл:

ArG-1 дугаарт булшнаас бугын эвэр, адууны эрүү, модон эдлэлийн хугархай, нохойн яс, хүний гавал, төмөр эдлэлийн хугархай, чулуун эдлэл (Зураг 18, 23).

ArG-2 дугаарт булшнаас нохойн бүтэн яс, дугуй хэлбэрийн үйсэн эдлэл, хүн, малын яс, нумын ясан наалт, гичир, хээтэй хаш эдлэлийн хугархай, 2 ш цоолбор хээтэй төмөр арал, дэгээ хэлбэрийн металл эдлэл, үйсэн эдлэлийн үлдэгдэл, цөгцөн ёроолтой төмөр тогоо, чулуун хэлтэй хүрэл хонх, ширэн эдлэлийн хэсэг, сур болон даавуун эдлэлийн үлдэгдлүүд илэрсэн (Зураг 19, 20, 21, 24, 25, 26).

ArG-3 дугаарт булшнаас хүн, малын яс, шатсан модны хугархай, том, жижиг 4 ш ваар, ясан савхны хугархай, чий будагтай эдлэлийн үлдэгдэл, 2 ш сувс илэрсэн (Зураг 22, 27, 32).

ArG-4 дугаарт булшнаас хүн, малын яс, нумын наалт, төмөр эдлэлийн хэсгүүд, богийн ясаар хийсэн дашмагийн ясан бөглөөтэй амсар, ясан арал, дөрвөлжин хэлбэртэй голдоо нүхтэй жижиг ясан эдлэл (чимэглэл), голдоо нүхтэй бөөрөнхий ясан эдлэл, дугуй хэлбэрийн билүү чулуу, чулуун зэвсэг (залтас), халбаган толгойтой ясан савх, сувс, чий будгийн хэсгүүд, төмрийн үлдэгдэл илэрсэн (Зураг 28, 29).

ArG-5 дугаарт булшнаас хүн малын яс, бугын эвэр, хүрэл толины хагархай хэсэг 2 ш, төмөр хутганы хугархай, ваарын хагархай илэрч олдсон.

ArG-6 дугаарт булшнаас хүний яс, төмрийн хугархай хэсгүүд, төмөр эдлэлийн үлдэгдэл, жижиг хэмжээтэй төмөр цутгуурын шанага, дугуй хэлбэрийн модон эдлэл, үйсний хэсгүүд, ваарын хагархай, том хэмжээтэй бүтэн ваар, чулуун хэлтэй хүрэл хонх, тааран эдлэлийн тасархай зэрэг гарсан (Зураг 30, 31, 33, 34).

ArG-35 дугаарт булшнаас хүний яс (бүтэн) нумын гичир, нумын ясан наалт, төмөр эдлэлийн үлдэгдэл илэрсэн.

Палеоантропологийн судалгаа. Ар гүнтийн дурсгалт газар малтан судалсан ArG-1, 2, 3, 4, 5, 6, 35 булшнаас олдсон хүний ясыг судалж нас, хүйс, өндрийг гаргаж урьдчилсан үр дүнг гаргасан. Эдгээр 7 булшны 6 нь эрт цагт тонуулчдын хөлөөр сүйдэж хүний ясны хэрэглэгдэхүүн анхны байрлалаа алдаж эмх замбараагүй болсон байсан бол ArG-35 дугаартай булш тонуулчдын гарт өртсөн хэдий ч ямар нэг байдлаар хүний яс хөндөгдөөгүй

анатомийн байрлалаараа үлджээ. Насны хувьд залуу нас, идэр нас, өтөл насны хүний яснууд илэрчээ. Судалгаанд хамрагдсан хүний яснаас харахад 5 эрэгтэй, 2 эмэгтэй байх ба эрэгтэйчүүдийн дундаж өндөр 167,5 см, эмэгтэй 154 см. Насны хувьд 20-34 насных 14%, 35-49 насных 29%, 50+ 57% эзэлж байна (Эрэгзэн, Энхболд нар., 2022).

Түүнчлэн ArG-2 дугаартай булшнаас илэрсэн хүний ясан дээр хэд хэдэн эмгэг шинжүүд илэрсэн. Амьд ахуй цагтаа тухайн хүний дээд эрүүний бүх шүд унаж шүдний түүш мөлийсөн болох нь харагдаж байна. Дагзны баруун талд мохоо зүйлээр цохиулсан, цөмөрсөн ором байх бөгөөд энэ нь үхлийн шалтгаан болсон байж болох юм. Мөн амьд ахуй цагт нь зүүн талын шилбэний яс доод хэсгээрээ, тахилзуур яс дээд хэсгээрээ хугарч хоорондоо 5-10 см зөрж бороолж эдгэрсэн байна. Энэ нь тухайн хүн амьд ахуй цагтаа доголж хазганаж явдаг байсныг харуулж байна. Мөн зүүн талын тавхайн яс шилбэний яснаасаа салаагүй арьстайгаа нийлсэн байдалтай байна. Мөн түүнчлэн малтлагаар илэрч олдсон хүний ясны дээжийг Унгар улсын Абасар дахь булшны үлдэгдэлтэй харьцуулан археогенетикийн судалгаа хийсэн байна. Ингэхэд филогенетикийн шинжилгээгээр Ар гүнтийн ArG-6 дугаартай булшны эзэн Монголын өндөрлөгөөс Унгарын тал хээр лүү нүүдэллэсэн анхны цагаач элитүүдтэй холбоотой болохыг тогтоожээ (Gergely I B, 2024).

Хүснэгт 2. Булшнаас илэрсэн хүний ясны мэдээлэл

Дурсгалын дугаар	Нас	Хүйс	Хүний ясны хадгалалт
ArG-1	+45	Эрэгтэй	80%
ArG-2	53-56	Эрэгтэй	95%
ArG-3	36-39	Эмэгтэй	75%
ArG-4	25-35	Эрэгтэй	65%
ArG-5	45-46	Эмэгтэй	-
ArG-6	66-70	Эрэгтэй	-
ArG-35	55-57	Эрэгтэй	-

Зооархеологийн судалгаа. Малтан судалсан 7 булшнаас адуу, үхэр, хонь, ямаа, нохой, буга гэсэн 6 н төрлийн мал болон амьтны яс илэрч олдсон байна. Энэ 1250 гаруй ширхэг яс бөгөөд тоо толгойгоор авч үзвэл хамгийн их нь 34 хонь, 20 ямаа, 14 үхэр, 9 адуу, 3 нохой, 3 бугын яс илэрч олсон. Илэрсэн малын ясны хэрэглэгдэхүүн бараг бүх булшинд бүх мал дээр ижил бөгөөд гавлын яс, эрүүний яс, хүзүүний нугалам, нурууны нугалам, дал, ууц, сүүлний нугалам, шагайт чөмөг, шагай, турууны үеүд байна.

ArG-6 дугаартай булшнаас илэрсэн адууны доод эрүүний ясан дээр шатаасан ул мөр байсан нь адууны ясыг шатааж тахил өргөсөн байх

магадлалтай.

ArG-1 болон ArG-2 дугаарт булшнаас илэрсэн үхрийн толгойн ясны дээд хэсэгт том мохоо зүйлээр цохисны ул мөр үлдсэн байх ба үүнийг магадгүй үхлийн шалтгаан байж болох юм гэж үзэж болно.

Түүнчлэн эдгээр булшнууд нь маш ихээр тоногдож анхны байрлалаа алдсан учир аль нь хөмөгтөө аль яс нь тахилын хэсэгтээ байсан нь тодорхой бус болсон байсан. ArG-1 болон ArG-2 дугаарт булшны хөл талаас нохойн яс илэрч олдсон. Тухайн илэрч олдсон 2 нохой нас бие гүйцсэн тайга (борзой), банхар үүлдрийн нохойнууд байж болохоор харагдаж байна (Эрэгзэн, Энхболд нар., 2022).

Дүгнэлт

Ар гүнтийн хүннүгийн булш, оршуулгын дурсгалт газар 2022 онд хийгдсэн археологийн малтлага судалгаа нь Төв монголын буюу Улаанбаатар хот орчим дахь хүннүгийн дурсгал соёлын судалгаанд шинэ, өндөр ач холбогдолтой эх сурвалж бүрдүүлээ. Хайгуул судалгаагаар дурсгалын бүтэц, тархалтын талаарх өмнөх бүртгэл шинэчлэгдэн нийт 41 булш бүхий томоохон оршуулгын цогцолбор болох нь тогтоогдсон бөгөөд тэдгээрээс сонгож малтсан 7 булш нь оршуулгын бүтэц, тахилгын зан үйл, эдийн соёлын онцлогоороо хүннүгийн археологийн судалгаанд өмнө тэмдэглэгдээгүй олон шинэ баримтыг илрүүлэв.

Малтлагын үр дүнд илэрсэн 1250 гаруй археологийн болон зооархеологийн хэрэглэгдэхүүн нь хүн болон мал амьтны олон төрлийн яс, мод, төмөр, хүрэл, ваар, яс, үйс зэрэг материалтай эд өлгийн зүйлсээр баялаг бөгөөд цаашид лабораторийн түвшний нарийвчилсан судалгаа хийх олдворын цуглуулга бүрдэв. Тэдгээрийн дундаас цөгцөн ёроолтой том хэмжээтэй төмөр тогоо болон дашмагийн ясан бөглөөтэй амсар зэрэг ховор олдворууд нь хүннүгийн булшнаас урьд өмнө бүртгэгдэж байгаагүй шинэлэг эд өлгийн зүйлс бөгөөд Ар гүнтийн булшны өвөрмөц байр суурийг тодотгож байна.

Оршуулгын бүтэц, ялангуяа ArG-1, ArG-2 булшны нүхний ханын 2 см зузаантай улаан зосон өнгөлгөө нь Монгол дахь хүннүгийн археологийн дурсгалд анх удаа тэмдэглэгдсэн тохиолдол бөгөөд оршуулгын зан үйлийн өнгө будгийн хэрэглээ, бэлгэдлийн утга агуулгыг судлах шинэ чиглэлийг нээж байна. Мөн булшнуудын заримд хойлгын хөмөг илэрсэн нь тахилгын зан үйлийн бүтэц, үйл явцыг сэргээн тайлбарлах нөхцөлийг бүрдүүлээ.

Палеоантропологийн судалгаагаар хүний нас, хүйс, бие бялдрын онцлог, эмгэг шинжийг нарийвчлан тодорхойлсон бөгөөд ArG-2 булшнаас илэрсэн ясанд хийсэн судалгаагаар олон удаагийн

биеийн гэмтэл авсан ул мөр илэрсэн нь тухайн үеийн амьдралын хэв маяг, эрүүл мэндийн нөхцөлийн талаар чухал мэдээлэл өгч байна.

Түүнчлэн 2024 онд Унгар улсын Унгар судлалын хүрээлэн, Байгалийн шинжлэх ухааны түүхийн музейн судлаачид Ар гүнтийн ArG-06 булшнаас авсан хүний ясны дээжийг Унгарын дундад зууны түүхэнд голлох үүрэг гүйцэтгэж байсан Аба овгийн 6 язгууртны булшнаас авсан дээжтэй харьцуулан тэдгээр нь эцгийн талаараа Ар гүнтийн дурсгалыг үлдээгч хүннү нартай холбогдож байгааг тогтоосон.

Зооархеологийн судалгаагаар адуу, үхэр, хонь, ямаа, нохой, буга зэрэг зургаан төрлийн мал амьтны яс илэрсэн нь хүннүгийн тахилга, зан үйлийн бүтцийг тодруулах боломж олгов.

Зарим адууны ясанд шатаалтын шинж илэрсэн, мөн үхрийн гавлын ясан дээрх цохилтын ул мөр тогтоогдсон нь тахил үйлдэхдээ мал амьтныг зориуд бэлтгэн ашиглаж байсан болохыг харуулна.

Эдгээр цогц үр дүн Ар гүнтийн хүннүгийн оршуулгын дурсгал нь хүннүгийн оршуулгын зан үйл, эдийн соёл, тахил тайлга, Евразийн өргөн уудам нутаг дахь соёл-биологийн харилцааг судлахад чухал эх сурвалж болохыг батлан харууллаа. Мөн илэрсэн материаллаг болон биологийн хэрэглэгдэхүүнд хийх цаашдын изотоп, генетик зэрэг шинжилгээнүүд нь энэхүү дурсгалын археологийн ач холбогдлыг улам баяжуулан гүнзгийрүүлэх боломжтой юм.

Холбогдох он цагийн хувьд ArG-6 дугаарт булшнаас илэрсэн малын ясанд хийсэн Радиокарбон (C14)-ны судалгаагаар НТӨ 120 – НТ 28 онд хамаарах болохыг тогтоогоод байна.

“Азийн хүннүчүүд ба европын хүннүчүүдийн түүх соёлын харилцаа, хамаарлын судалгаа” төслийн судалгааны ажил хоёр жил завсарлаад энэ жил буюу 2025 онд Ар гүнтийн дурсгалт газар үргэлжлүүлэн ажиллаж 6 булшийг малтан судлаад байгаа ба одоогоор боловсруулалтын ажил явагдаж байна.

НОМ ЗҮЙ

Ванчигдаш, Ч., Эрдэнэболд, Л., Хатанбаатар, Д., Базаргүр, Д., Анхсанаа, Г., Ариунболд, Г., Одбаяр, З., Болормаа, С., Амарбилэг, Ч. *Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх археологийн дурсгалууд*. Улаанбаатар, 2021.

Мандах, Д. Ар гүнтийн дурсгалаас илэрсэн ямааны толгойн ясан дээр хийсэн судалгааны зарим үр дүн. *Археологийн судлал*. Т. XLV, Fasc. 4, Улаанбаатар, 2024: 37-49.

Эрэгзэн, Г., Батболд, Н., Энхболд, С., Содномжамц, Д. Монгол нутаг дахь хүннүгийн археологийн дурсгалууд газрын зураг. Хүннүгийн эзэнт гүрний үеийн булш, оршуулгын дурсгалууд: Судалгаа хадгалалт хамгаалалт, сурталчилгаа

төсөл. Улаанбаатар, 2022.

Эрэгзэн, Г., Энхболд, С., Мандах, Д., Амарболд, Э. Монгол, Унгарын хамтарсан “Азийн хүннүүд ба европын хүннүүдийн харилцаа, хамаарлын судалгаа” төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс. *Монголын археологи-2022*. Улаанбаатар, - 2022: 79-84.

Эрэгзэн, Г., Энхболд, С., Мандах, Д., Амарболд, Э. Монгол, Унгарын хамтарсан “Азийн хүннүүд ба европын хүннүүдийн харилцаа, хамаарлын судалгаа” төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2022. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ.

AMS Radiocarbon Dating Report, 2023. Ar Gunt Site, Belkh Site and Tuuliin Khar Tun Site (Mongolia). Institute of Accelerator Analysis Ltd. Kawasaki.

Renfrew, C., Bahn, P. *Archaeology: Theories, Methods, and Practice*. New York, 1991.

Gergely I B Varga, Zoltán Maróti, Oszkár Schütz, Kitti Maár, Emil Nyerki, Balázs Tihanyi, Orsolya Várad, Alexandra Ginguta, Bence Kovács, Petra Kiss, Monika Dosztig, Zsolt Gallina, Tibor Török, János B. Szabó, Miklós Makoldi, Endre Neparáczi. Archaeogenetic analysis revealed East Eurasian paternal origin to the Aba royal family of Hungary. *Iscience*. Volume 27, Issue 10, 18 (2024): 1-30. <https://doi.org/10.1016/j.isci.2024.110892>

White, T.D., Folkens, P.A. *The human bone manual*. Elsevier Academic Press, 2005.

REFERENCES

Vanchigdash, Ch., Erdenebold, L., Khatanbaatar, D., Bazargur, D., Ankhsanaa, G., Ariunbold, G., Odbayar, Z., Bolormaa, S., Amarbileg, Ch. *Ulaanbaatar khotyn nutag devsgar dekh arkheologiin dursгалууд*. Ulaanbaatar, 2020.

Mandakh, D. Ar guntiin dursгалаас илersen yamaany tolgoin yasan deer khiisen судалгааны зарим үр дүн. *Arkheologiin судлал*. Tomus XLV, Fasciculus 4, Ulaanbaatar, 2024: 37-49.

Eregzen, G., Batbold, N., Enkhbold, S., Sodnomjamts, D. “Mongol nutag dakh khünnügiin archeologiin dursгалууд” газрын зураг. Hünngügiin

ezent gürnii üyiin bulsh, orshuulgyn dursгалууд: Sudalgaa, khadgalalt khamgaalalt, surtalchilгаа түсүл. Ulaanbaatar, 2024.

Eregzen, G., Enkhbold, S., Mandakh, D., Amarbold, E. Mongol, Ungaryn khamtarsan “Aziin khünnüchүүд ба Evropyin khünnüchүүдiiin түүkh, soyolyn khariltsaa khamaarlyн судалгаа” төслийн 2022 ony kheeriin судалгааны ажлын uridchilsan үр дүнgees. *Mongolyn archeologi-2022*. Ulaanbaatar, 2022: 79-84.

Eregzen, G., Enkhbold, S., Mandakh, D., Amarbold, E. Mongol, Ungaryn khamtarsan “Aziin khünnüchүүд ба evropyin khünnüchүүдiiin түүkh, soyolyn khariltsaa khamaarlyн судалгаа” төслийн 2022 ony kheeriin судалгааны ажлын тайлан. Ulaanbaatar, 2022. Arkheologiin khureelengiin GBSKH.

AMS Radiocarbon Dating Report, 2023. Ar Gunt Site, Belkh Site and Tuuliin Khar Tun Site (Mongolia). Institute of Accelerator Analysis Ltd. Kawasaki.

Renfrew, C., Bahn, P. *Archaeology: Theories, Methods, and Practice*. New York, 1991.

Gergely I B Varga, Zoltán Maróti, Oszkár Schütz, Kitti Maár, Emil Nyerki, Balázs Tihanyi, Orsolya Várad, Alexandra Ginguta, Bence Kovács, Petra Kiss, Monika Dosztig, Zsolt Gallina, Tibor Török, János B. Szabó, Miklós Makoldi, Endre Neparáczi. Archaeogenetic analysis revealed East Eurasian paternal origin to the Aba royal family of Hungary. *Iscience*. Volume 27, Issue 10, 18 (2024): 1-30. <https://doi.org/10.1016/j.isci.2024.110892>


White, T.D., Folkens, P.A. *The human bone manual*. Elsevier Academic Press, 2005.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Хавсралт 1. Ар гүнтийн оршуулгын дэвсгэр болон малтлага, олдворын зураг



Зураг 1. Булины байрлал, зохион байгуулалт



Зураг 2. Ар гүнтийн хуннугийн булины байршил.




Зураг 3. 1-р булины оршуулгын нүх



Зураг 4. 1-р булины дэвсгэр зураг




Зураг 5. 2-р булины оршуулгын нүх



Гар зураг 6. 2-р булины дэвсгэр зураг



Зураг 7. 3-р булины оршуулгын нүх



Гар зураг 8. 3-р булины дэвсгэр зураг



Зураг 9. 4-р булины оршуулгын нүх



Гар зураг 10. 4-р булины дэвсгэр зураг



Зураг 11. 5-р булины оршуулгын нүх



Гар зураг 12. 5-р булины дэвсгэр зураг




Зураг 13. 6-р булшны ориуулгын нүх



Гар зураг 14. 6-р булшны дэвсгэр зураг



Зураг 15. 35-р булшны ориуулгын нүх



Гар зураг 16. 35-р булшны дэвсгэр зураг



Зураг 17. 1-р булшны хананы зос



Зураг 18. 1-р булшинаас илэрсэн бугын эвэр



Зураг 19. 1-р булины оршуулга, тахилын хэсэг



Зураг 20. 2-р булины оршуулга, тахилын хэсэг



Зураг 21. 3-р булины оршуулга, тахилын хэсэг



Зураг 22. 4-р булинаас илэрсэн хүний оршуулга



Зураг 23. 5-р булинаас илэрсэн хүний оршуулга



Зураг 24. 35-р булины оршуулгын хэсэг



Зураг 25. 6-р булины хөмөг



Зураг 26. 1-р булинаас илэрсэн хүн малын яс



Зураг 27. 2-р булинаас илэрсэн бог бод малын яс



Зураг 28. 2-р булинаас илэрсэн нохойн яс



Зураг 29. 2-р булинаас олдсон цөгцөн ёроолтой төмөр тогоо



Зураг 30. 3-р булинаас илэрсэн ваар, бог малын яс



Зураг 31. 1-р булинаас илэрсэн чулуун эдлэл



Зураг 32. 2-р булинаас илэрсэн хүрэл хонх



Зураг 33. 2-р булинаас илэрсэн хүрэл арал



Зураг 34. 2-р булинаас илэрсэн мөнгөн дэгээ



Зураг 35. 2-р булинаас илэрсэн үйсэн эдлэл



Зураг 36. 4-р булинаас илэрсэн ясан эдлэл



Зураг 37. 4-р булинаас илэрсэн хүрэл толь



Зураг 38. 6-р булинаас илэрсэн цутгуурын шанага



Зураг 39 3-р булинаас илэрсэн ясан савх



Зураг 40. 3-р булинаас илэрсэн ваар



Зураг 41. 3-р булинаас илэрсэн ваар



Зураг 42. 6-р булинаас илэрсэн ваар



Зураг 43. 2-р булинаас илэрсэн цөгцөн ёроолтой
төмөр тогоо



Зураг 43. 2-р булинаас илэрсэн цөгцөн ёроолтой
төмөр тогоо

Хавсралт 2. Ар гүнтэд малтсан ArG-6 дугаарт булины ясанд хийсэн он цагийн судалгаа

Lab Number	Sample Code	Provenance	Material Type	Pretreatment	$\delta^{13}\text{C}$ (‰) (AMS)	Data with $\delta^{13}\text{C}$ Correction	
						Conventional ^{14}C Age (yrBP)	pMC (%)
IAAA-221082	No.1	Ar Gunt site (ArG-2022)	tooth	CoEx	-21.57 $\pm$ 0.41	2,040 $\pm$ 30	77.53 $\pm$ 0.25

Table 2. Radiocarbon age without $\delta^{13}\text{C}$ correction and calibrated age

Lab Number	Data without $\delta^{13}\text{C}$ Correction		Age for Calibration (yrBP)	Calibrated Age (1 σ)	Calibrated Age (2 σ)
	Age (yrBP)	pMC (%)			
IAAA-221082	1,990 $\pm$ 30	78.07 $\pm$ 0.25	2,044 $\pm$ 26	92calBC - 78calBC (9.9%) 54calBC - 9calAD (58.4%)	151calBC - 132calBC (2.8%) 120calBC - 28calAD (91.3%) 47calAD - 57calAD (1.3%)

